

Түүх 10: Рут болон түүний сайхан сэтгэлт бэр

Библийн эшлэл
[Рут 1:166]

Таны сүүх газарт би ч сууна. Таны ард түмэн миний ард түмэн,
таны Бурхан миний Бурхан. (Рут 1:166)

Дээр үед, Израилийн Бетелхем хотод айхтар өлсгөсөн болжээ.

Тухайн үед Бетелхемд амьдарч байсан Елимелех гэх хүн эхнэр болон хоёр хүүгээ дагуулан Моаб уруу нүүжээ.

Гэтэл хэдэн жилийн дараа Елимелех нас баржээ.

Хөвгүүд нь том болцгоож Моаб эмэгтэйчүүдтэй гэрлэжээ. Үүнээс хойш арваад жил өнгөрөв.

Гэтэл хоёр хүү нь ч бас өвчнөөр нас барцгаажээ.

Ингээд ээж Наоми нь хоёр бэр болох Опра, Рутын хамт үлдэв.

Төрсөн нутаг болох Израильд нь өнтэй сайхан жил болж байгааг сонсоод Наоми төрсөн нутгаа ихэд санан буцхыг хүсэв.

Наоми төрсөн нутаг уруугаа явахаасаа өмнө хоёр бэр болох Рут, Орпа хоёрыг дуудав.

“Та нар минь төрсөн гэр уруугаа буц даа. Би төрсөн нутаг уруугаа буцах боллоо.”

Тэр гурав салах болсондоо гуниглан хамтдаа тэврэлдээд үйлцгаажээ. Орпа бэр нь төрсөн гэр рүүгээ буцахад, харин сайн бэр Рут хадам ээжээсээ салсангүй. Рут Наомид ингэж хэлжээ.

“Таны явах газарт би явах болно. Таны Бурхан бол миний Бурхан. Тиймээс намайг яв гэж битгий ятгаач.”

Ингээд Наоми Рут хоёр хамтдаа Израилийн Бетелхемийг зорин явцгаав.

Бетелхем дэх хүмүүс Наоми Рут хоёрыг хараад мэл гайхав.

Тариан талбайгаас ургац хураах цаг болжээ. Хүмүүс ургацаа хураахаар тариалангийн талбай уруу явцгаав.

Харин Наоми, Рут хоёрт тариан талбай ч байсангүй, туслах хүн ч байсангүй.

Сайхан сэтгэлт бэр Рут нь идэх хоол олохын тулд тариан талбай уруу явжээ.

Рут талбайд ирээд тариан түрүү түүж байлаа. Талбайн эзэн болох Боаз түүнийг харав. Боаз зарцаасаа асуув.

“Тэр залуу эмэгтэй хэн бэ?” Зарц хариулав.

“Аан, тэр бол хадам ээж Наомигаа дагаад ирсэн Моаб эмэгтэй Рут гэдэг эмэгтэй билээ.” Боаз зарцдаа хэлэв.



“Тариа хураахдаа Рутад зориулж үлдээж байгаарай.”

Рут гэртээ ирэхэд хадам ээж нь түүнээс ингэж асуув.

“Охин минь, хаанаас ийм их тариан түрүү аваад ирэв?”

“Ээж ээ, Боаз гэгч хүний талбайгаас тариан түрүү түүгээд ирлээ.”

Наоми ингэж хэлэв.

“Өө тийм үү, Боаз бол манай хамаатны хүн. Цаашид тэнд л очиж тариан түрүү түүж байгаарай.”

Рут Боаз хоёр гэрлэхивэл сайхан даа гэж Наоми боджээ.

Өдөр бүр өөрийнх нь талбайд ирж тариан түрүү түүж байгаа үзэсгэлэнтэй Рутад Боаз дурласан байлаа.

Ингээд Наоми өөрийн бэр Рутыг Боазтай гэрлэхийг зөвшөөрчээ.

Удалгүй Боаз Рут хоёр гэрлэн хуримаа хийлээ.

Бурхан Боаз Рут хоёрыг ерөөгөөд хүүтэй болгожээ. Наоми маш их баярлав.

Боаз хүүгээ Обед гэж нэрлэжээ.

Обед нь Израиль улсын хамгийн агуу хаан болох Давид хааны өвөө байлаа.



Үйл ажиллагаа 1. Доорх асуултанд хариулаарай.

а. Наомигийн бэрүүдийн нэр хэн хэн бэ?

б. Наомитай хамт Моабаас Израиль уруу хамт ирсэн хүн хэн байсан бэ?



с. Рут 1:16 эшлэлийг уншаад хариулаарай. Ноами Рутад ээжийнхээ гэр лүү буцаж явахтун гэхэд Рут хадам ээж Наомид юу гэж хэлсэн бэ?

● Дараах библийн эшлэлийг уншаад цээжлээрэй. (Рут1:16б)

Таны ард түмэн миний ард түмэн, таны Бурхан миний Бурхан.





Үйл ажиллагаа 2.

Доорх зургийг хайчилж аваад хуруун хүүхэлдэй хийгээрэй.





Нэр :